МОНГОЛЫН
ШҮҮГЧДИЙН ХОЛБОО
Чингэлтэй дүүрэг 1-р хороо,
Жигжиджавын гудамж, Хангарьд ордон,
Шүүгчдийн холбооны байр, 7 давхарт 709 тоот
Утас: 70114100, +976 99081135
E-mail: contact@judge.mn

2026.11.02 № 39

танай _____-ны _____-т

ШҮҮГЧДИЙН ХОЛБООНЫ САЛБАР ТЭРГҮҮН НАРТ

Төслийн хувилбарт санал авах хуваарь хүргүүлэх тухай

Нийт шүүгчийн III чуулганаас гаргасан зөвлөмжийн дагуу байгуулагдсан Ажлын хэсгээс боловсруулсан 19 бүлэг, 69 зүйл бүхий "Шүүгчийн ёс зүйн стандарт"-ын төсөл болон түүний үзэл баримтлалыг нийт шүүгчдэд танилцуулах, салбар хороодоор дамжуулан санал авах ажиллагааг эхлүүлж байна.

Иймд Холбооны салбар тэргүүн нар Ажлын хэсгийн уриалгыг хүлээн авч, салбар хурлыг зохион байгуулан, шүүгч нэг бүрт Шүүгчийн ёс зүйн стандартыг танилцуулахын хамт санал авах ажлыг дараах хуваарийн дагуу хэрэгжүүлнэ үү.

Нэг. Ажлын хэрэгжилтийн хуваарь:

1. 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл:
   - Шүүгчид болон шүүхийн салбар хороод "Шүүгчийн ёс зүйн стандарт"-ын төсөлтэй биечлэн танилцаж, судлах.
2. 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн:
   - Шүүхийн салбар хороод дотооддоо хэлэлцүүлэг зохион байгуулж, саналаа нэгтгэх (Уг хэлэлцүүлгийг зөвлөгөөн биш Салбар хорооны хэлэлцүүлэг хэлбэрээр явуулна).
3. 12 дугаар сарын 11-ний өдрийн дотор:
   - Салбар хороод хэлэлцүүлгийн тэмдэглэл болон нэгтгэсэн саналыг Шүүгчдийн Холбооны contact@judge.mn цахим хаягаар ирүүлэх. (ирүүлсэн саналыг Ажлын хэсэгт нэгтгэн хүргүүлэх болно)
   - /Уриалгыг хавсаргав/

ТЭРГҮҮН **Д.БАТБААТАР**